

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/28/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.14 № 01/231
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ДОГСМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ-Идэр сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 39,465.8 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эмийн 48,301.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 25,000.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс 12,424.7 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийж нөөц үүсгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 4 зорилтын хүрээнд 43 заалт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>185,937,330.56</u>	<u>183,746,643.01</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,271,170.00	39,465,817.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	34,271,170.00	39,465,817.38
3121	Төгрөг	34,271,170.00	39,465,817.38
31211	Төрийн сангийн харилцах	34,271,170.00	39,465,817.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,271,170.00	39,465,817.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	34,271,170.00	39,465,817.38
3121	Төгрөг	34,271,170.00	39,465,817.38
31211	Төрийн сангийн харилцах	34,271,170.00	39,465,817.38
33	АВЛАГА	43,263,700.00	12,600.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	12,600.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	43,263,700.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	108,402,460.56	144,268,224.87
351	Түүхий эд материал	35,499,564.11	52,664,358.91
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	35,499,564.11	52,664,358.91
354	Хангамжийн материал	72,902,896.45	91,603,865.96
35410	Бичиг хэргийн материал	741,500.00	1,293,800.00
35420	Аж ахуйн материал	18,055,570.00	27,174,020.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,349,100.00	1,411,100.00
35440	Түлш, шатах тослох материал	4,117,620.00	965,800.00
35450	Барилгын засварын материал	202,890.00	202,890.00
35460	Хүнсний материал	11,476,247.50	21,630,474.50
35470	Бусад хангамжийн материал	36,959,968.95	38,925,781.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,865,343,594.84</u>	<u>2,014,923,409.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,865,343,594.84	2,014,923,409.22
392	Биет хөрөнгө	1,843,285,594.84	1,993,050,409.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,615,871,546.28	1,615,871,546.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-102,605,033.40	-140,823,590.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,166,896.55	69,012,896.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,630,137.94	-25,352,930.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	252,105,504.01	505,711,149.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,438,045.08	-114,879,870.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,604,100.00	51,604,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,726,332.77	-17,431,367.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,306,459.80	62,306,459.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,369,362.61	-12,967,984.77
393	Биет бус хөрөнгө	22,058,000.00	21,872,999.92
39301	Програм хангамж	1,250,000.00	1,690,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-625,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	20,808,000.00	20,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,051,280,925.40</u>	<u>2,198,670,052.23</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,051,280,925.40</u>	<u>2,198,670,052.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,051,280,925.40	2,198,670,052.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,284,554.00	435,284,554.00
51101	Өмч: - төрийн	435,284,554.00	435,284,554.00

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	1,526,576,189.70	1,673,965,316.53
51210	Өмнөх үеийн үр дүн	1,526,576,189.70	1,526,576,189.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	147,389,126.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,420,181.70	89,420,181.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,051,280,925.40</u>	<u>2,198,670,052.23</u>

СТ-2А

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,368,337,901.75	1,180,087,634.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,942,071.75	302,513,478.06
120	Нийтлэг татварын бус орлого	310,942,071.75	302,513,478.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	250,191,363.75	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	250,191,363.75	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	301,054,030.00	877,574,156.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	71,290,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	71,290,900.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	756,341,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,951,740.00	659,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,839,840.00	659,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,618,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	77,275,686.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	77,275,686.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,811,390.00	799,639,470.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,811,390.00	799,639,470.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,142,121,558.48	1,032,698,507.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,121,558.48	1,032,698,507.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,005,057.48	1,030,502,087.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,888,770.00	532,147,403.62
210101	Үндсэн цалин	260,945,820.00	280,306,460.39
210102	Нэмэгдэл	154,664,107.00	159,142,169.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,620,000.00	6,295,778.00
210104	Урамшуулал	117,448,454.00	61,402,995.87
210105	Гэрээт ажлын хөлс	15,210,389.00	25,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,022,400.00	67,359,046.24
210201	Тэтгэврийн даатгал	47,867,700.00	47,052,948.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,038,700.00	5,078,599.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,000.00	4,063,019.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,007,600.00	1,004,378.24
210205	Эрүүл мэндийн даатгал	10,077,400.00	10,160,102.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,773,331.25	63,149,180.00

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	5,651,422.00	3,996,880.00
210302	Түлш, халаалт	58,082,209.25	58,203,900.00
210303	Цэвэр, бохир ус	39,700.00	948,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,876,153.75	56,724,848.00
210401	Бичиг хэрэг	2,930,600.00	4,775,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,239,973.75	24,064,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,600.00	3,315,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,444,980.00	24,569,128.00
2105	Нормативт зардал	270,740,806.22	123,990,348.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	259,204,261.97	114,105,115.75
210502	Хоол, хүнс	11,536,544.25	9,885,233.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,732,900.01	25,300,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	7,511,950.00
210604	Урсгал засвар	2,732,900.01	17,788,500.00
2107	Томилолт, зочны зардал	743,000.00	2,240,000.00
210702	Дотоод албан томилолт	743,000.00	2,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,034,600.00	1,795,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	379,500.00	893,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	52,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,700.00	27,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000.00	00.00
210807	Газрын төлбөр	93,100.00	102,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,193,096.25	157,794,830.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,150,536.00	23,483,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,042,560.25	134,311,830.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,116,501.00	2,196,420.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,900,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,700,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,216,501.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,216,501.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,196,420.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,196,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>226,216,343.27</u>	<u>147,389,126.83</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,211,369.61	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,211,369.61	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-18,211,369.61	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>208,004,973.66</u>	<u>147,389,126.83</u>

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,014,132,130.00	920,837,856.00
120004	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		43,263,700.00
1200045	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		43,263,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,014,132,130.00	877,574,156.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	71,290,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	71,290,900.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	756,341,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,688,040.00	659,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,839,840.00	659,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,618,900.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	77,275,686.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	77,275,686.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,811,390.00	799,639,470.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,811,390.00	799,639,470.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	895,369,960.00	883,683,208.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	895,369,960.00	883,683,208.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,253,459.00	881,486,788.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,888,770.00	532,147,403.62
210101	Үндсэн цалин	260,945,820.00	280,306,460.39
210102	Нэмэгдэл	154,664,107.00	159,142,169.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,620,000.00	6,295,778.00
210104	Урамшуулал	117,448,454.00	61,402,995.87
210105	Гэрээт ажлын хөлс	15,210,389.00	25,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,022,400.00	67,371,647.00
210201	Тэтгэврийн даатгал	47,867,700.00	47,052,948.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,038,700.00	5,078,599.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,000.00	4,063,019.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,007,600.00	1,016,979.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,077,400.00	10,160,102.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,993,358.00	61,102,180.00
210301	Гэрэл, цахилгаан	5,651,422.00	3,996,880.00
210302	Түлш, халаалт	59,302,236.00	56,156,900.00
210303	Цэвэр, бохир ус	39,700.00	948,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,714,360.00	45,552,228.00
210401	Бичиг хэрэг	2,238,000.00	2,550,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,914,760.00	22,960,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,600.00	3,315,000.00

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	165,000.00	70,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,191,000.00	5,881,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,945,000.00	10,775,928.00
2105	Нормативт зардал	86,685,215.00	116,715,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,575,365.00	84,076,440.00
210502	Хоол, хүнс	14,109,850.00	20,039,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	12,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,885,100.00	28,202,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,901,100.00	275,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,984,000.00	9,935,450.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	17,992,100.00
2107	Томилолт, зочны зардал	743,000.00	2,240,000.00
210702	Дотоод албан томилолт	743,000.00	2,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,121,020.00	4,671,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	465,920.00	1,061,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	52,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,700.00	27,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000.00	00.00
210807	Газрын төлбөр	93,100.00	102,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	2,707,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,200,236.00	23,483,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,200,236.00	23,483,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,116,501.00	2,196,420.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,900,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,700,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,216,501.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,216,501.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,196,420.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,196,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>118,762,170.00</u>	<u>37,154,647.38</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>84,491,000.00</u>	<u>31,960,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>84,491,000.00</u>	<u>31,960,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>84,491,000.00</u>	<u>31,960,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	84,491,000.00	31,960,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-84,491,000.00</u>	<u>-31,960,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,271,170.00	5,194,647.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,271,170.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,271,170.00	39,465,817.38

СТ-4А

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	147,389,126.83	147,389,126.83
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,673,965,316.53	2,198,670,052.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	925,531,400.00	913,446,788.62	12,084,611.38	98.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	925,531,400.00	913,446,788.62	12,084,611.38	98.7
210	Бараа, үйлчилгээний зардал	925,531,400.00	913,446,788.62	12,084,611.38	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,074,500.00	532,147,403.62	8,927,096.38	98.4
210101	Үндсэн цалин	256,725,200.00	280,306,460.39	(23,581,260.39)	109.2
210102	Нэмэгдэл	185,266,400.00	159,142,169.36	26,124,230.64	85.9
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	12,000,000.00	6,295,778.00	5,704,222.00	52.5
210104	Урамшуулал	62,082,900.00	61,402,995.87	679,904.13	98.9
210105	Гэрээт ажлын хөлс	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,634,400.00	67,371,647.00	262,753.00	99.6
210201	Тэтгэврийн даатгал	47,235,400.00	47,052,948.00	182,452.00	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,099,800.00	5,078,599.00	21,201.00	99.6
210203	ҮОМШӨ ний даатгал	407,970,000.00	4,063,019.00	16,681.00	1.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,000.00	1,016,979.00	3021.00	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	10,199,500.00	10,160,102.00	39,398.00	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,298,600.00	61,102,180.00	2,196,420.00	96.5
210301	Гэрэл цахилгаан	6,193,300.00	3,996,880.00	2,196,420.00	64.5
210302	Түлш, халаалт	56,156,900.00	56,156,900.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	948,400.00	948,400.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	46,552,700.00	45,652,228.00	900,472.00	98.1
210401	Бичиг хэрэг	2,707,900.00	2,550,200.00	157,700.00	94.2
210402	Тээвэр (шатахуун)	22,960,100.00	22,960,100.00		100.0

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,450,000.00	3,415,000.00	35,000.00	99.0
210404	Ном, хэвлэл	137,500.00	70,000.00	67,500.00	50.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,089,300.00	5,881,000.00	208,300.00	96.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	11,207,900.00	10,775,928.00	431,972.00	96.1
2105	Нормативт зардал	117,235,300.00	116,715,900.00	519,400.00	99.6
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,218,200.00	84,076,440.00	141,760.00	99.8
210502	Хоол, хүнс	20,417,100.00	20,039,460.00	377,640.00	98.2
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	12,600,000.00	12,600,000.00		100.0
2106	Эд хогшил худалдан авах	59,053,800.00	59,722,550.00	(668,750.00)	101.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,300,000.00	19,995,000.00	(695,000.00)	103.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	11,761,700.00	11,735,450.00	26,250.00	99.8
210604	Урсгал засвар	17,992,100.00	17,992,100.00		100.0
2107	Томилолт, зочны зардал	2,707,900.00	2,240,000.00	467,900.00	82.7
210702	Дотоод албан томилолт	2,707,900.00	2,240,000.00	467,900.00	82.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,709,100.00	5,078,580.00	630,520.00	89.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,400.00	1,501,780.00	498,620.00	75.1
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	720,000.00	686,700.00	33,300.00	95.4
210803	Даатгалын үйлчилгээ	75,400.00	52,200.00	23,200.00	69.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,400.00	27,300.00	48,100.00	36.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	27,300.00		27,300.00	0.0
210807	Газрын төлбөр	102,700.00	102,700.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,707,900.00	2,707,900.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	24,999,600.00	23,383,000.00	1,616,600.00	93.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,999,600.00	23,383,000.00	1,616,600.00	93.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	929,190,400.00	920,837,856.00	8,352,544.00	99.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,276,000.00	77,275,686.00	(314.00)	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	77,276,000.00	77,275,686.00	(314.00)	100.0
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	848,255,400.00	849,877,756.00	1,622,356.00	100.2
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	848,255,400.00	849,877,756.00	1,622,356.00	100.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	659,000.00	659,000.00		100.0

131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	659,000.00	659,000.00		100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,271,170.00	(34,271,170.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	39,465,817.38	(39,465,817.38)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35	35	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

¹ "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай"

² "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай"

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 01-ны өдрийн А/10 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 заалт бүхий 7 ажлын хүрээнд графикт хяналт шалгалтыг зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл

ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 147,389.1 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,271.2	39,465.8	5,194.6
Авлага	43,263.7	12.6	-43,251.1
Бараа материал	108,402.4	144,268.3	-35,865.9
Үндсэн хөрөнгө	1,865,343.6	2,014,923.4	-149,579.8
Нийт хөрөнгө	2,051,280.9	2,198,670.0	147,389.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,051,280.9	2,198,670.0	147,389.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,051,280.9	2,198,670.0	147,389.1

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данснуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 5,194.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 35,865.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 149,579.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 283,891.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 31,900.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 251,991.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй буюу улсын төсөв, орон нутгийн төсвөөс ирсэн хөрөнгө авсантай холбоотой байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 43,263.7 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна. Мөн нийгмийн даатгалаас жирэмсэн амаржсаны зөрүүгээр 12,6 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал санаас 847,903.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт

77,275.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн. Нийт зарлагыг 920,178.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас хангамж бараа материалын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр бууруулж, 842,903.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 5,000.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгож, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 842,903.2 мянган төгрөгийг, Орон нутгийн урсгал санхүүжилтээс үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 842,903.2 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 77,275.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 918,638.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	308,212.8	301,827.1	6,385.7	97.9 %
2	Үндсэн тусламж үйлчилгээ	449,468.7	451,161.1	1.7	100.0%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	90,573.9	90,573.9	0	100.0%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	71,094.2	71,092.0	2.2	99.8%
5	Нийтлэг үйлчилгээ	3,984.3	3,984.3	0	100.0%
	Дүн	923,333.9	918,638.4	6,389.6	99.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 43263,7 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ-идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэ-идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,142,121.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,842.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 15,989.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 12,770.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 32,825.3 мянган төгрөгийн 5 гүйлгээ, орлого илүү

мэдээлсэн 22,973.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ нийт 68,570.1 мянган төгрөгийн 9 гүйлгээг илүү дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар акт, албан шаардлага өгөөгүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, И-баримтыг татварын цахим системд шивж оруулаагүй талаар 2 зөвлөмж өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	9,800.0	2	9,800.0	100.0
Нийт дүн	2	9,800.0	2	9,800.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 48,301.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 25,000.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 157,283.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 66,646.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 90,637.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 52,805.2 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бараа материалын тайланг анхан баримттай тулган шалгахад нийгмийн эрүүл мэндийн зардал болох 23,383.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 4 бүлэг "Бараа материал" хэсгийн 4.21 дахь заалт "4.21 Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг " гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 90,637.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 90,637.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр 12,424.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³ дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

2. Бараа материал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 1,793.3 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7⁴ гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 6,757.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 12,770.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 32,825.3 мянган төгрөгийн 5 гүйлгээ, орлого илүү мэдээлсэн 22,973.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ нийт 68,570.1 мянган төгрөгийн 9 гүйлгээг илүү дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

³ "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁴ "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлогыг мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тайлагнасан	1	43,263.7			1	43,263.7	1	43,263.7				
Бараа материалын дансаар дамжуулалг үй шууд зарлагдсан	1	23,383.0			1	23,383.0	1	23,383.0				
Дүн	2	66,646.7			2	66,646.7	2	66,646.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Илүү материал нөөцөлсөн	1	12,424.7					1	12,424.7				
Анхан шатны баримт дутуу	1	2,884.6					1	2,884.6				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	6,757.6					1	6,757.6				
Дүн	3	22,066.9					3	22,066.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй	1	12,770.9					1	12,770.9
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй		32,825.3						32,825.3
Орлогын гүйлгээг илүү мэдээлсэн		22,973.8						22,973.8
Дүн	1	68,570.1					1	68,570.1

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

